

ДЭЛХИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ АНГИЛАХ ТУХАЙД

Г.Баасанхүү*

“Соёл иргэншил” хэмээх нэр томъёо, ухагдахууны тухайд

Соёл иргэншил хэмээх нэр томъёо нь *civilis*¹ буюу иргэн, хотын оршин суугч гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд яг энэ утгаар нь өрнөдийн олонхи судлаачид соёл иргэншлийг тодорхойлсоор ирсэн. Хамгийн анх энэхүү нэр томъёог Францын маркиз де В.Р Мирабо 1757 онд бичсэн “Хуулийн нөхөд” номондоо хэрэглэсэн бөгөөд тэрээр соёл иргэншил бол нийт хууль дүрмийг үнэ цэнэтэй болгож байдаг биеэ зөв авч явах соёл хүмүүжил, ёс зүйн цогц гэж тодорхойлсон². Удалгүй энэ нэр томъёог дараа дараагийн судлаачид өргөнөөр хэрэглэх болсон бөгөөд энэ нь тэр үеийн Европын улсуудын гадаад бодлого, тэр дундаа колоний бодлого идэвхижсэнтэй шууд холбоотой. Яг энэ үеэс “Соёл иргэншил бол цагаан арьстнуудад хамаарах ба бусад нь хоцрогдсон бүдүүлэг зэрлэгүүд” хэмээх тодорхойлолт судалгаанд нэвтэрсэн. Нөгөө талаар колоний бодлоготой холбоотой Европ урьд мэддэггүй асан олон олон үндэстэн улсыг, тэдний түүх, хэл, соёлыг мэдэх болсон билээ.

XX зуун гарснаар соёл иргэншил хэмээх ойлголтод бүхэл нийгэм өөрийн онцлог хүрээ, хүчин зүйлтэйгээ багтах болтол өргөн хүрээтэй ойлгогдох болж, энэ нь ч дээрх томъёог нэг мөр тодорхойлох аргагүй нарийн ярвигтай ухагдахуун болгосон.

Өнөөдөр бараг бүх толь, сурах бичгүүдэд зохиогч бүр өөрийн ухаарснаар соёл иргэншлийг тайлбарлан тодорхойлсон байдаг.

Ер нь аливаа ухагдахуунд тодорхойлолт өгөхийн тулд түүнийг тодорхойлох шалгуурыг тодотгох ёстой. Энэ утгаар соёл иргэншлийг тусгайлан судлаачид, эрдэмтэд соёл иргэншил хэмээх биеэ даасан онолыг, түүнийг судлах шинжлэх ухааны салбар ухааныг, судалгааны биеэ даасан арга барил, үзэл баримтлалыг үүсгэн хөгжүүлсэн билээ. Эдүгээ соёл иргэншлийг судлах онолын

* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

¹ Э.В.Тадевосян, “Словарь-справочник по социологии и политологии”, М., 1996г., стр 250

² “Сравнительное изучение цивилизаций”, составитель Б.С.Ерасов., М., 2001., стр 10

үндсэн 3 сургууль, дэг сургууль нэгэнт бий болжээ. Тухайлбал, материалист сургуулийнхан, түүхэн-соёлын сургуулийнхан, харьцуулсан буюу шинэчлэгчдийн дэг сургуулийнхныг нэрлэж болно.

Эдгээр онолын сургуулиуд нь өөр хоорондоо соёл иргэншлийг онолын хувьд чухам ямар шалгуураар тодорхойлох, гол шалгуураар алийг авч үзэх зэргээсээ хамааран ялгарч ирсэн бөгөөд материалист сургуулийнхан хүний нийгмийн хөгжлийн материаллаг ахуй, ахуйд суурилсан харилцааг гол болгон авч үздэг тул нийгмийн шинжлэх ухаантай нягт холбогддог.

Харин түүхэн-соёлын сургуулийнхан судалгааны гол шалгуур, объектоор хүн, хүмүүний нийгмийн харилцааг авч үзсээр ирсэн тул хэл, соёл, түүх, шашин, философи зэрэг хүмүүнлигийн шинжлэх ухааны олон салбар ухааныг баяжуулан хөгжүүлэхийн хамтаар түүхэн-соёлын гэх цоо шинэ онолын сургуулийг үндэслэсэн юм. Соёл-түүхийн сургуулийнхны онолын шалгуур, харьцуулалт, судалгааны арга барилыг бидний судлаачид дэмжин буй тул цаашид энэхүү онолын сургуулийн хандлагыг голлов.

Соёл иргэншил судлаачдын өгсөн тодорхойлолт, онолын сургуулийн ялгаатай байдлаас үл хамааран соёлоос ялгагдах соёл иргэншлийн нийтлэг шалгуур байна гэж үзэж болно. Соёл иргэншил нь францын материалист “Аннал” дэгийнхний судалснаар доорх 4 төрлийн дэд системээс бүрдсэн цагт сая нэгэн бүхэл цогц систем болох юм. Энэ нь эдийн засгийн, нийгэм-социологийн, улс төрийн, соёл-сэтгэхүйн дэд системүүд буюу шалгуурууд юм. Үүнд:

1. Социологийн шалгуурын хувьд хүн, хүмүүний нийгмийн оршин амьдрахад, амьдралын хэмнэлд зайлшгүй шаардагдах гэр бүлээс эхлэн төр хүртлэх хоол хүнс, эдлэл хэрэглэл, хөдөлмөр зэргийг багтаасан бүхий л харилцаа;
2. Эдийн засгийн буюу үйлдвэрлэл, эрэлт нийлүүлэлт, харилцаа холбоо, хэрэглээтэй холбогдох шалгуурууд;
3. Улс төрийн дэд системийн хувьд хүмүүсийн хоорондын бүхий л харилцааны хэлбэрүүд, иргэний амьдрал, хууль, зан заншил;
4. Оюуны амьдралын бүхий л хэлбэрүүдийг багтаасан соёл-сэтгэхүйн шалгуурууд бөгөөд нэг үгээр хэлэхэд соёлын шалгуур. Эдгээр дэд системүүд нэгдэн бүхэл цогцыг буюу сая соёл иргэншил хэмээх

ухагдахууныг үүсгэнэ. Харин чухам аль шалгуурыг гол болгохоос хамаарч онолын хандлага, олон тодорхойлолтууд ялгарч байгаа гэж ойлгож болно.

Гэвч тэдгээрийг сайтар судалбал 7 төрлийн нийтлэг тодорхойлолт гарч болохыг Оросын соёл иргэншил судлаач Б.С.Ерасов судлан тогтоосон байна.³

1. Соёл иргэншил бол нийгэм юм. Иймд соёл иргэншил нь нийгмийн бүх төрлийг улс төр, эдийн засаг, соёл нийгмийг багтааж байдаг. Энэ тодорхойлолтыг Г. Мишо, Э. Марк⁴ нарын бүтээлд харж болно. Энэ тодорхойлолт нь хэтэрхий өргөн утгатай, тодорхойгүй тул нийгмийн олон янз хэлбэрийг тодорхойлохыг шаарддаг.
2. Соёл иргэншил бол хот, хотын иргэд юм. П.Бэгби, жишээ нь соёл иргэншил бол хоттой холбоотой соёл юм гэсэн⁵. Энэ нь өрнөдийнхний дунд газар авсан тодорхойлолт бөгөөд дээр дурьдсан Европын колоничлолын үетэй холбоотой. Нөгөөтэйгүүр энэ тодорхойлолтоор соёл иргэншилийг судалбал түүний тоо хэдэн зууд хүрч бараг томоохон хот болгоныг соёл иргэншил гэж үзэх хэрэгтэй болно.
3. Соёл иргэншил бол өндөр хөгжилтэй орнуудын нийтлэг байдал технологийн өндөр түвшинд хүрч, хувь хүний эрхийг хангах, иргэн, улс төрийн байгууллын хэлбэр юм. Энэхүү тодорхойлолтоор өрнөдийнх биш бол соёл иргэншил биш мэт⁶. Энд “соёлт цагаан арьстан ба балмад зэрлэг” хэмээх ухагдахуун 200 гаруй жилийн турш байсаар байгааг харж болно. Энэ нь хэтэрхий явцуу хэт соёл иргэншилийг өрнөджүүлсэн хэрэг юм.
4. Соёл иргэншил бол хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахаар сайтар зохион байгуулагдсан хүмүүжлийн нийгэм юм⁷. Энэ тодорхойлолт мөнөөх л колоничлолтой холбоотой бөгөөд соёлт хүний ариун үүрэг бол “соёлын үрийг зэрлэгүүдэд танилцуулахад оршино” гэсэн явцуу зарчимтай холбоотой байжээ.

³ “Сравнительное изучение цивилизаций”, составитель Б.С.Ерасов., М., 2001., стр.19

⁴ “Современные теории цивилизаций”, под.ред.И.Н.Ионовым., Раздел I., М.,1995., стр.21

⁵ “Современные теории цивилизаций”, под.ред.И.Н.Ионовым., Раздел I., М.,1995., стр.7

⁶ “Сравнительное изучение цивилизаций”, составитель Б.С.Ерасов., М., 2001., стр.22

⁷ “Сравнительное изучение цивилизаций.Хрестоматия”, составитель Б.С.Ерасов., М., 2001., стр.23

5. Соёл иргэншил гэдэг бол хүмүүний үйл ажиллагааны үр дүн юм. Өөрөөр хэлбэл хүн хөгжлийн шат ахисны илрэл гэж үздэгийг тодорхойлсон⁸.

6. Соёл иргэншил бол томоохон нийгмийн дэлхийн түүхэнд өөрийгөө тодотгож үлдээсэн, харуулж буй чанарын онцлог⁹ бөгөөд тэр нь нийгэм, оюуны амьдралаар, амьдралын үнэт зүйлсээрээ бусдаас ялгагддаг. Энэ тодорхойлолтоор соёл иргэншил нь дэлхийн шашингуудтай давхцан ойлгогддог. Яг энэ тодорхойлолт нь соёл иргэншлийг нэг үндэстний нийгэм-соёлын нийгэмлэгийг нөгөөд сөргүүлэн ойлгуулдаг бөгөөд энэ утгаар нэгдмэл түүхийн уламжлалтай. Нэг хариуцлагатай нийгэмлэг улс гэдэг ойлголттой соёл иргэншил давхцдаг.

7. Соёл иргэншил бол нэгдмэл ерөнхий хязгаар нутгаас хамт гарсан тухайлбал, дэлхийн шашингууд, ёс зүйн, эрх зүйн тогтолцоогоор илэрхийлэгдсэн үнэт зүйлд тулгуурлан үндэслэсэн нийгэм-соёлын нийтлэг юм¹⁰ гэсэн тодорхойлолтыг сүүлийн үед судлаачид оноон тодорхойлж ирлээ.

Бид энэхүү тодорхойлолтыг хамгийн сонгодог тодорхойлолт гэж үзэж байгаа бөгөөд “Үндэстэн дамнасан соёл бүрдэх явц төгсч, бие даасан философи буюу дэлхийн шашин үүсгэсэн үед Соёл иргэншил үүснэ”¹¹ гэсэн шалгуурыг голлож байна.

Соёл иргэншлийн ангиллын тухай

Судлаачид онолын аль сургуульд хамаарч байгаагаас үл хамааран өөрсдийн үзэл баримтлалаар соёл иргэншлийг маш олон янзаар ангилсан байдаг. Жишээ нь, хамгийн нийтлэг ангилал болох амьд ба сөнөсөн, өрнөдийн ба дорны, хотын ба тосгоны буюу хөдөөгийн, нүүдлийн ба суурьшмал, төвийн ба зах

⁸ О.Шпенглер. "Закат Европы: Очерки морфологии мировой истории.", М., 1993., стр.323-338

⁹ "Сравнительное изучение цивилизаций. Хрестоматия", составитель Б.С.Ерасов., М., 2001., стр.24

¹⁰ Мөн тэнд., стр.25

¹¹ Г.С.Померанц. "Выход из транса", М.,1995., стр.210,

Г.С.Померанц, "Сравнительное изучение цивилизаций", М.2001., стр.25

хязгаарын гэх мэт. Эс бөгөөс дэлхийн шашингуудад тулгуурласан ангилал зэргийг дурдаж болно.

А.Тойнби хүн төрөлхтний түүхийн сүүлийн 1000 жилийн явц дахь 21 иргэншлийг “өдөөлт-хариулт” гэсэн детерминизмийн зарчмаар нарийвчлан судлаж, соёл иргэншил буюу хөгжлийн өсөлт-хөгжил-уналт байдаг гэж дүгнэн, 21-ийг 14 болгож, эцэст нь өрнөдийн загалмайтны, үнэн алдартны византийн, лалын, энэтхэгийн, алс дорнодын гэсэн таван соёл иргэншлийг тогтоосон юм¹².

Соёл иргэншлийг амьд (Европын) ба мөхсөн (эртний Египетийн, Колумбын өмнөх Америкийн), амьд соёл иргэншлийг орчин үеийн (өрнөдийн) ба түүхэн (Хятадын, Энэтхэгийн) гэж ангилахаас гадна соёл иргэншлийг бүсчлэн судлах, бас үндэсний гэж авч үзэж болох юм.

Дэлхийн соёл иргэншлийг зарим судлаачид эрхлэх аж ахуйгаас нь нүүдлийн ба суурин гэж ангилсан байна.¹³

Орчин цагт олон улсын харилцаанд нөлөөлөхүйц амьд соёл иргэншлүүд нь 7-8 байна гэдэгтэй олон судлаачид санал нэгддэг.

Дэлхийн соёл иргэншлүүд нь нэгдмэл бүтэцтэй бөгөөд цаг хугацааны хувьд маш тогтвортой, хэдэн зууны туршид бэхжин хөгжсөөр байдгаас гадна бүтцийн хувьд олон дэд соёл иргэншлээс бүрдэж байдаг. Өрнөдийн соёл иргэншил Баруун Европын сонгодог ба Умард Америкийн, лал нь Арабын, Персийн, Бага Азийн, алс дорнодын соёл иргэншил нь Хятад, Япон, Солонгосын г.м.

Соёл иргэншлийг ийн олон янзаар ангилах нь судлаачдын ангилах шалгуураас шууд хамаарна. Зарим судлаачид амьдралыг, ертөнцийг үзэх үзлийг, нөгөө нь шашин шүтлэгийг, гуравдахь нь нийгмийн байгуулал, амьдралын хэвшлийг нь гол шалгуур болгон ангилсан байдаг талаар дээр тодорхой өгүүлсэн билээ.

Энэ талаар соёл иргэншил гэж юу вэ, ямар шалгуурыг гол болгон соёл иргэншил ба соёлыг ялгах, соёл иргэншлүүдийг хооронд нь ангилах талаар өнөөг хүртэл нэгдсэн тайлбарт хүрээгүй байна. Учир нь соёл иргэншил хэмээх ухагдахуун нь задлан шинжилж ойлгоход нэн ярвигтай амьд систем юм.

¹² Ю.В.Яковец, “Соёл иргэншлийн түүх”, УБ.2000

¹³ ЖБаясах. “Нүүдлийн хийгээд суурин соёл иргэншлийн ялгаа, харилцан хамаарлын асуудалд” “Зүүн Хойд Азийн байдал төлөв”, УБ.2003., х.249-263

Г.Мишо, Э.Марк нарын үзлээр соёл иргэншил нь өөрөө өөрийгөө зохион байгуулах чадвартай бөгөөд дотроо түвшингүүдтэй хоёр талын нээлттэй систем бөгөөд хэвтээ шугамаар үндэстэн хоорондыг, босоо шугамаар үндэстэн дамнасан харилцааг үүсгэж байдаг.¹⁴

Соёл иргэншлүүд үүсч, хөгжлийн оргилд хүрч, задарч, мөхдөг. Түүний хөгжил нь өөрийн гэсэн шинж чанартай байж, тодорхой үе шатыг туулж байдаг. Олон төрөл, олон салаа шугамтай байдаг. Иймээс ч хүн төрөлхтний түүхийн 35-40 мянган жилд хэдэн арван соёл иргэншил үүсч, хөгжиж, мөхөж ирсэн.

А.Тойнби, О.Шпенглер нар дунджаар аливаа соёл иргэншил үүслээс задрал хүртлэх үеийг туулахдаа нэг мянган жил насалдаг гэж үзсэн бол Л.Гумилев 1.5 мянган жил насалдаг гэсэн. Аливаа соёл иргэншил мөн өөрийн ареал, хил хязгаартай бөгөөд энэ нь улс төр-газар зүйн хилээс арай өөр байдлаар, тухайлбал, тархалтаараа тодорхойлогддог. Түүхээс харахад соёл иргэншил нь үндэстний хэв шинж, хил хязгаараас гадна хамааралтай юм.

Аливаа соёл иргэншлийг илэрхийлэх үндсэн хэдэн шинж чанар байдаг нь сэтгэхүй сэтгэлгээн дэх нийтлэг үндсэн төрх, хэв шинж, түүх улс төрийн хувь заяа ойр нэгдмэл байдал, эдийн засгийн хөгжлийн нийтлэг харилцаа холбоо, соёлын нэг нэгэндээ ууссан байдал, хөгжлийн чиг хандлагын зүгээс илрэх нийтлэг ашиг сонирхол, зорилго бөгөөд гол нь сэтгэлгээ юм гэдгийг соёл иргэншлийг ангилахдаа анхаарах нь зүйтэй болов уу.

Соёл иргэншил гэдэг бол адил төстэй нэгдмэл сэтгэлгээний үндсэн үнэт зүйлс, идеалтай, нийгэм-улс төрийн байгуулал, эдийн засаг, соёлын тогтвортой онцлог дүр төрхтэй хүмүүсийн бүлэглэл юм.

Бидний тодорхойлолтоор соёл иргэншлийг өрнөдийн (эх газрын сонгодог ба шинэчлэгдсэн Америкийн гэсэн 2 урсгалтай), Евразийн буюу Оросын, лалын, буддын, Энэтхэгийн, алс дорнодын буюу зүүн Азийн, бусад буюу хязгаарын соёл иргэншлүүд \иудейн, латин америкийн, африкийн гэх мэт\ гэж ангилж болох юм.

Монгол улс чухам аль соёл иргэншилд хамаарах талаар судлаачид харилцан адилгүй байр суурь баримталдаг.

¹⁴ Michaud G., Mark E. "Ver une science des civilizations?", Bruxelles, 1981., p.41-59

Зарим судлаачид Монголыг буддын соёл иргэншилд багтаадаг ч¹⁵, зарим нь алс дорнодын соёл иргэншилд багтаан авч үзсэн байдаг¹⁶. Бидний санахад Алс Дорнодын соёл иргэншилд Монголыг багтаах нийтлэг үндэслэлүүд байна гэж үзэж байгаа.¹⁷

Соёл иргэншил бүр өөрийн онцлогтой. Соёл иргэншил бол нэг ёсны билэг тэмдгийн цогц тогтолцоо бөгөөд гагцхүү түүнийг зөв тайлан уншихыг эрмэлзэх хэрэгтэй билээ.

¹⁵ Samuel P. Huntington. "The Clash of Civilizations and the Remaking of World Order", NY. 1996, p.48

¹⁶ А.Тойнби. "Постимперское общество", М.2002., стр.62

¹⁷ Г.Баасанхүү "Зүүн Азийн соёл иргэншилд Монголын холбогдох нийтлэг үндэслэлүүд", "Зүүн Хойд Азийн төлөв, байдал ба Монгол улс", УБ.2003.,х.275-288